

БАТЛАВ.  
МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ  
ХХК-ИЙН ГҮЙЦӨТГӨХ ЗАХИРАЛ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗҮҮНХАРАА САЛБАРЫН  
БАЙРНЫ ДЭЭВРИЙН ЗАСВАРЫН АЖЛЫН  
ТЕХНИКИЙН ДААЛГАВАР**

1...1...ХУУДАС/

ТАНИЛЦСАН:

А.ГАНТУЛГА  
ТЕХНОЛОГИЙН УДИРДЛАГА,  
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ

ХЯНАСАН:

Ц.ОДХҮҮ  
СТРАТЕГИ, САНХҮҮ БОРЛУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ

БОЛОВСРУУЛСАН:

Н.ИЧИНХОРЛОО  
ДЭД БҮТЭЦ ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2024.01.10.

1. **Барилга байгууламжийн байршил:** Сэлэнгэ аймаг, Мандал сумын 7 дугаар баг.
2. **Ажлын зориулалт:** Салбарын байрны дээврийн засварын ажил
3. **Барилгын ерөнхий үзүүлэлт:** 1980 онд ашиглалтанд орсон, холбооны ашиглалт үйлчилгээний зориулалтаар ашиглагдаж байгаа, ашиглалтын байдал хэвийн 1 давхар барилга. Барилгын хийц бүтээцийн хувьд цутгамал бетон суурьтай, угсармал бетон хучилт араг бүтээц, 64 см-ийн тоосгон дүүргэлттэй хана, барилгын тэнхлэг хоорондын нийт талбай 372.7 м.кв, төвийн дулаан, цэвэр ус, цахилгааны нэгдсэн сүлжээнд бүрэн холбогдсон, барилгын өндөр 3.3 м.
4. **Гүйцэтгэгчид тавигдах ерөнхий шаардлага:**
  - 4.1. Дээврийн ажлыг дулааны улиралд чанарын өндөр түвшинд, ажлын тоо хэмжээ, зураг төсөвт тусгасаны дагуу, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
  - 4.2. Дээврийн ажлыг гүйцэтгэхдээ Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, БНБД стандарт шаардлагад (Дээвэр болон ус тусгаарлалтын хуйлмал материалын техникийн ерөнхий шаардлага МЫ5 6303-201, ус үл нэвтрүүлэх хуйлмал материал ТУ 5774-002-13157915-98) нийцүүлэн, Дээврийн ажил БНБД 31-07-05-ийг мөрдлөг болгоно.
  - 4.3. Ажлыг гүйцэтгэхдээ тухайн байршилд ажил үйлчилгээ явуулж байгаа бусад байгууллагуудад саад бэрхшээл учруулахгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэн талбайн зохион байгуулалтыг хийж, шаардлагатай тэмдэг тэмдэглэгээ, санамжийг байршуулан ажиллах шаардлагатай.
  - 4.4. Ажил гүйцэтгэх явцад талбайд ажиллаж буй ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч ажиллах ба үүнээс гарах хор хохирлыг өөрсдөө хариуцна. Барилга угсралтын ажилд хэрэглэгдэх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар БД 12-101-05 мөрдөнө.
  - 4.5. Галын аюулгүй ажиллагааны дүрэм журам, стандартыг хангасан байна. (БНБД 21.02.02, БНБД 21.01.02)
5. **Угсралтын ажлын үед тавигдах бусад шаардлагууд:**
  - 6.1. Нийт 419 м.кв талбай бүхий барилгын одоо байгаа хар цаасан хавтгай дээврийг цэвэрлэн, тусгай түрхлэг, болон тусгаарлагч дэвсэн дээврийн ус тусгаарлалт LOGICBASE V-SL 1.5мм зузаан полимер мембраныг хийх.
  - 6.2. Парапет төмөрлөж засварлана.
  - 6.3. Дээврийн хар цаас, борооны ус зайлуулах шугамын ажил, ус тусгаарлах, хөрсжүүлэлтийн ажлыг гүйцэтгэхдээ ус тусгаарлах материалын угсралтыг технологийн дагуу гүйцэтгэнэ. (MNS 6303:2011 Дээвэр болон ус тусгаарлалтын хуйлмал материал, Техникийн ерөнхий шаардлага)
  - 6.4. Борооны ус зайлуулах шугам хоолойг шинээр хийж, хог хаягдлаас хамгаалах шүүр, таг тавьж өгнө.
  - 6.5. Ажлын явцад гарсан хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт хаях ба ажил дууссаны дараа талбайг цэвэрлэж хүлээлгэн өгнө.
  - 6.6. Барилгын засварын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.
  - 6.7. Гүйцэтгэсэн ажлыг ил, далд ажлын акт, фото зургаар баталгаажуулсан байна.

## ТӨСӨВТ ӨРТГИЙН НЭГДСЭН ТОВЧОО

Д/Д	Зардлын нэр	Бүгд өртөг /төгрөг/
1	Ажиллах хүчний зардал	7,614,778
2	Материал	24,825,891
3	Тээвэр	397,512
4	Машин ашиглалт	409,027
	<b>Шууд зардлын дүн</b>	<b>33,247,209</b>
5	Барилгын удирдлага, зохион байгуулалтын зардал /61 %/	2,373,126
6	Ашиг / 15%/	5,343,050
	<b>Барилга угсралтын ажлын дүн</b>	<b>40,963,386</b>
7	НӨАТ 10%	4,096,339
8	Нормчлолын сан 0.18%	73,734
	<b>Дүн</b>	<b>45,133,458</b>
9	Захиалагчийн техник хяналтын зардал	819,268
10	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	0
11	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	409,634
	<b>Дүн</b>	<b>46,362,360</b>
12	Магадлашгүй ажил 2 %	819,268
13	Бусад нэмэлт зардал	0
	<b>Дүн</b>	<b>47,181,628</b>

## АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

9.1 ДЭЭВРИЙН АЖИЛ /32Х14М/			
Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Барилгын дээврийн хог зөөж цэвэрлэх, шүүрдэх	м2	419
2	Дээврийн 1 үе тусгаарлагч түрхлэг хийх	м2	419
3	Мөн нийлэг хальс 1 үе дэвсэж тусгаарлалт хийх	м2	419
4	Дээврийн ус тусгаарлалт LOGICBASE V-SL 1.5мм зузаан полимер мембран хийх	м2	419
5	Мембран дээврийн хэвтээ заадсыг цахилгаан алхаар гагнах	м	320
6	Мембран дээврийн ам дарагч төмөр хадах	м	82
7	Парапет төмөрлөх	м2	22
8	2 налуут дааврийн карниз хэсэгт ус хаялага төмөр хийх	у/м	64
9	Дээврийн аэротоп суулгэх хэсэгт цементэн тэгшилгээ засварлаж сэргээх	м2	9
10	Мембраныг парапет болон салхивчийн яндан хэсэгт цоройлгон даруулга төмрөөр дарж хадах ба зай завсрыг нь зориулалтын силикон цавуугаар наах	1 газар	2
11	Барилгын хог ялгаж овоолох ба автомашинд эксковатораар ачих	м3	18